

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 11 дүгээр
сарын 4-ны өдөр

№ 30

Улаанбаатар хот

Компанийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2, 42 дугаар зүйлийн 42.1, 76 дугаар зүйлийн 76.1.5, 80 дугаар зүйлийн 80.2, Санхүүгийн зохицуулах хорооны Өрийн хэрэгслийн бүртгэлийн журмын 4.1, ХААН Банк ХК-ийн Дүрмийн 5.5 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн;

ХААН Банк ХК, Монгол Улсын нээлттэй хувьцаат компани (регистрийн дугаар 2693321, улсын бүртгэлийн дугаар 9007001013) (цаашид “Банк” гэх)-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд дараах тогтоолоор ХААН Банк ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 18 тоот тогтоолоор шийдвэрлэсэн асуудалд дараах өөрчлөлтийг үүгээр оруулан батлав. Үүнд:

ҮНДЭСЛЭЛ “Бондын хөтөлбөрийн (“Бондын хөтөлбөр”) хүрээнд гаргах бондуудыг хэсэгчлэн гаргах тухай бүр бондын хүүгийн нөхцөлийг тодорхойлох ба Ам.долларын бондын хувьд хөвөгч хүүтэй байх ба хүүгийн түвшин ам.долларын зах зээлийн 6 сарын “СМЕ Term SOFR” хүү дээр нэмэх нь жилийн 3.40-3.85% хязгаарт багтсан байх, харин Төгрөгийн бондын хувьд тогтмол хүүтэй байх ба хүүгийн түвшин жилийн 13.8-14.8% хязгаарт багтсан байхыг;” гэж заасныг “Бондын хөтөлбөрийн хүрээнд гаргах бондуудыг хэсэгчлэн гаргах тухай бүр бондын хүүгийн нөхцөлийг тодорхойлох ба Ам.долларын бондын хувьд хөвөгч хүүтэй байх ба хүүгийн түвшин ам.долларын зах зээлийн 6 сарын Compounded SOFR хүү дээр нэмэх нь жилийн 3.40%-3.85% хязгаарт багтсан байх, харин Төгрөгийн бондын хувьд тогтмол хүүтэй байх ба хүүгийн түвшин жилийн 14.8%-16.0% хязгаарт багтсан байхыг;” гэж өөрчлөх;

Дээрх саналыг Төлөөлөн удирдах зөвлөл хүлээн зөвшөөрснийг ҮНДЭСЛЭН, ийнхүү:

- 1. ТОГТООХ НЬ:** Бондын хөтөлбөрийг дээрх өөрчлөгдсөн нөхцөлийн дагуу хэрэгжүүлэхийг хүлээн зөвшөөрч баталгаажуулсугай.
- 2. ТОГТООХ НЬ:** Бондын танилцуулга дээр дурдсан нөхцөлүүдийг тусган нэмэлт өөрчлөлт оруулах, бусад шаардлагатай бичиг баримтад гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулах бүрэн эрхийг Гүйцэтгэх захирал болон ерөнхий нягтлан бодогч буюу Санхүү, захиргаа хариуцсан дэд захирал нарт олгосугай.
- 3. ТОГТООХ НЬ:** Монгол Улсын холбогдох хууль, хэм хэмжээ тогтоосон эрх зүйн актуудын хүрээнд төрийн эрх бүхий зохицуулагч байгууллагуудад Бондын хөтөлбөрт орж буй нэмэлт өөрчлөлтийг мэдэгдэх, зөвшөөрөл авах, шаардлагатай эсхүл зохистой гэж үзсэн холбогдох бүхий л баримт бичигт гарын үсэг зурах, баталгаажуулах, шаардлагатай бүх арга хэмжээг авч энэхүү тогтоолын гүйцэтгэлийг хангах бүрэн эрхийг Гүйцэтгэх захирал эсвэл түүний томилсон этгээдэд олгосугай.

4. **ТОГТООХ НЬ:** ХААН Банк ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 18 тоот тогтоолын дээрх өөрчлөлтөөс бусад хэсэг хэвээр үлдэхийг баталгаажуулсугай.

БАТЛАВ



Харада Ясунари

Ц.Баатарсайхан

Кисабүро Иший

Жон Ло

А.Тамир

Аарт Йонгяанс

Б.Амарсанаа

